| 2.3.7 | Усан замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах талаар орон нутгийн холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах | | Ажлын явц | Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудыг хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангах ажлыг Далайн захиргаанаас тогтмол зохион байгуулж байна. | **2-р улиралд:** Орон нутгийн байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж, хамтран ажиллана. | Усан замын тээврийн тухай хуулиар олгогдсон эрхийн хүрээнд холбогдох шийдвэрийг гаргуулах, орон нутгийн холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгч, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай албан бичгийг Нийслэлийн болон Хөвсгөл, Архангай, Баян-Өлгий, Увс, Булган, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Дорнод, Хэнтий аймгуудын Засаг дарга нарт 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр 1/174 тоотоор хүргүүлсэн. Уг албан бичгийн шийдвэрлэлтийн талаар тухайн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдтэй холбогдож, Усан замын тээврийн тухай хууль, тогтоомжийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг мөн зохион байгуулсан. Увс, Баян-Өлгий Архангай, Хөвсгөл аймгуудын Засаг даргын захирамж батлагдсан.<br><br>Усан замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зорилтын хүрээнд орон нутгийн холбогдох байгууллагын мэргэжилтэн, усан замын тээврийн хяналтын /ахлах/ байцаагч нарыг оролцуулсан цахим семинарыг 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан.<br><br>Тус семинараар усан замын тээврийн салбарт авч хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, төсөл хөтөлбөр, бүтээн | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллалтын ажлын талаар танилцуулж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх асуудлаар санал солилцож, хөвөлтийн улирлын хугацаанд орон нутагт усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, шалгалтыг хамтран хэрэгжүүлэхээр болж, ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн. Түүнчлэн семинарт оролцогчдоос ирүүлсэн хүсэлтийн дагуу Далайн захиргааны мэргэжилтэн, улсын байцаагч нар орон нутагт ажиллах хугацаандаа зарим нуурт усан замын тээврийн чиглэл, бүс тогтоосон захирамжийн төслийг боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахаар тохиролцов. | |
| 2.3.8 | Усан замын тээврийн хэрэгслийн 2023 оны техникийн хяналтын үзлэг, тооллогыг зохион байгуулах | | Ажлын явц | Усан замын тээврийн тухай хуульд заасны дагуу усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, тооллогыг жил бүр зохион байгуулдаг. | **1-р улиралд:** Техникийн хяналтын үзлэг, тооллого явуулах хуваарийг батална. Техникийн хяналтын үзлэг, тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэнэ. **2-р улиралд:** Техникийн хяналтын үзлэг, тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулна. **4-улиралд:** | Усан замын тээврийн хэрэгслийн 2023 оны техникийн хяналтын үзлэг, тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулах улсын байцаагчдын томилолтын ажлын хуваарь, удирдамжийг Далайн захиргааны даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/16 дугаар тушаалаар баталсан ба шаардлагатай зардлын төсвийг байгууллагын 2023 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусган батлуулсан.<br><br>Техникийн хяналтын үзлэг, тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэх ажлыг хийж гүйцэтгэж байна.<br><br>Хуваарийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс техникийн хяналтыг үзлэг, тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулах ажил эхэлсэн. | **90** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Техникийн хяналтын үзлэг, тооллогын тайлан мэдээг ЗТХЯ-нд хүргүүлнэ. | Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Увс аймгийн хяргас, Баян-Өлгий аймгийн Толбо нуурт 2023 оны 06 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд зохион байгуулсан усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт нийт 30 завь хамрагдсанаас 28 нь тэнцэж, 2 завь тэнцээгүй дүнтэй байна. | |
| 2.3.9 | Усан замын тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | | Удирдамж, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, хувь | Далайн захиргааны мэргэжилтэн, улсын байцаагчид нь усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа талаар төлөвлөгөөт хяналт шалгалтыг жил бүр хийж гүйцэтгэж байна. | **1-р улиралд:** Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын төлөвлөгөө, удирдамжийг батална.<br>**3-р улиралд:** Батлагдсан удирдамжийн дагуу зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.<br>**4-р улиралд:** Тайланг ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлнэ. | Усан замын тээврийн хяналтын улсын байцаагчдын эрхийг сунгах, шинээр авах хүсэлтийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 1/25 тоот албан бичгээр ЗТХЯ-ны Салбарын хяналтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлсэн.<br><br>Мөн усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг улсын ахлах байцаагчтай хамтран боловсруулсан бөгөөд №4.4.1 дугаартай “Усан замын тээврийн аюулгүй байдлыг шалгах” хяналтын хуудсыг шинэчлэн батлуулахаар 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр ЗТХЯ-ны Салбарын хяналтын газарт хүргүүлсэн.<br>Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын удирдамжийг батлуулахаар ЗТХЯ-ны Салбарын хяналтын газартай хамтран ажиллаж байна.<br><br>Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газар болон Далайн захиргаа хооронд Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжийг 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан.<br><br>Тус удирдамжийн дагуу Архангай, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий аймгуудад 2023 оны 06 | **30** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 14-27-ны өдрүүдэд ажиллаж байна.<br><br>ЗТХЯ-ны Салбарын хяналтын газар, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий аймгуудын авто тээвэр, усан замын хяналтын улсын /ахлах/ байцаагч, Далайн захиргаа Усан замын тээврийн бүртгэл, хяналтын албаны мэргэжилтэн, улсын байцаагч нар хамтран 2023 оны 06 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд Хөвсгөл, Увс, Баян-Өлгий аймгуудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад нийт 12 иргэн, аж ахуйг нэгжийг хамруулав. Илрүүлсэн зөрчлийг арилгуулахаар иргэдэд улсын /ахлах/ байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлээд байна. | |
| 2.3.10 | Онцгой байдлын ерөнхий газартай байгуулсан хамтын ажиллагааны Санамж бичгийн хүрээнд усан замын тээврийн аюулгүй ажиллагаанд тавих хяналтыг хамтран хэрэгжүүлэх | | Үйл ажиллагааны явц | ОБЕГ-тай 2015 онд хамтын ажиллагааны Санамж бичгийг байгуулсан бөгөөд уг санамж бичгийн хүрээнд усан замын тээврийн аюулгүй байдалд тавих хяналт, урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээг | **1-р улиралд:** 2023 онд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батална.<br>**3-р улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хамтарч ажиллана.<br>**4-р улиралд:** Төлөвлөгөөний дагуу ажиллаж, биелэлтийг дүгнэнэ. | Хамтын ажиллагааны Санамж бичгийн дагуу 2023 онд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 1/54 тоот албан бичгээр хүргүүлсэн. Уг төлөвлөгөөг 2023 оны эхний улирал багтаан батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br><br>Хамтын ажиллагааны Санамж бичгийн дагуу 2023 онд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хамтран баталсан.<br><br>Тус төлөвлөгөөний дагуу “Хөвсгөл нуурт живсэн тээврийн хэрэгслийг татан гаргах ажиллагаа”-нд Далайн захиргаанаас усан замын тээврийн хяналт хариуцсан мэргэжилтэн, улсын байцаагчийг аврах завины хамт оролцуулахаар шийдвэрлээд байна. | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр батлан биелэлтийг ханган ажилладаг. | | Түүнчлэн Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулж буй техникийн хяналтын үзлэг тооллогод онцгой байдлын албан хаагчдыг оролцуулж, аврах болон гал унтраах хэрэгслийн бэлэн байдал, ашиглалтыг шалгуулсан. Онцгой байдлын албан хаагчидтай улсын байр наадмын үеэр эргүүл хяналтыг хамтран гүйцэтгэхээр төлөвлөөд байна. | |
| **ЗОРИЛТ 2.4 ОЛОН УЛСЫН ДАЛАЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН БУСАД ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ, БУСАД ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ БОЛОН ТЭДГЭЭРИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТӨД МОНГОЛ УЛС НЭГДЭН ОРОХОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ, ОЛОН УЛСЫН ХӨЛӨГ ОНГОЦНЫ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ПЛАТФОРМЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЭХ** | | **Ажлын явц** | | **Байгууллагын дүрмийн 4.1.4 дэх заалт** | | **Олон улсын гэрээ, конвенц, бусад холбогдох баримт бичиг болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтүүдийг судалж, олон улсын 1 конвенцын 2 нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орж, олон улсын хөлөг онгоцны мэдээллийн нэгдсэн платформыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.** | |
| 2.4.1 | Олон улсын далайн байгууллага болон бусад олон улсын байгууллагын олон улсын гэрээ, конвенц, бусад холбогдох | | Судалгааны үе шат | Байгууллагын дүрмийн 4.1.4 дэх заалт | **2-р улиралд:** Олон улсын гэрээ, конвенц, болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орох эсэх талаар судална. **4-р улиралд:** | “Далайг хог хаягдал болон бусад зүйлсээр бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай” 1975 оны конвенц болон “Далайн тээврийн хөдөлгөөнийг хөнгөвчлөх тухай” 1965 оны конвенцод тус тус нэгдэн орох талаар судалгаа хийгдэж байна мөн конвенцуудын хамгийн сүүлийн нэмэлт өөрчлөлтүүдийг багтаасан хувилбаруудыг | **30** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баримт бичиг болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтөд Монгол Улс нэгдэн орох эсэх талаар санал боловсруулан холбогдох мэдээлэл бэлтгэх | | | | Нэгдэн орох шаардлагатай олон улсын гэрээ, конвенц, болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийг орчуулж, ГХЯ-аар хянан баталгаажуулах ажлыг ЗТХЯ-нд уламжилж, хуулийн төслийн үзэл баримтлал, холбогдох танилцуулгын хамт хүргүүлнэ. | монгол хэлнээ хөрвүүлэх ажил хийгдэж байна. | |
| 2.4.2 | “Далайн хөдөлмөрийн тухай” 2006 оны конвенцын 2016 болон 2018 оны нэмэлт өөрчлөлтүүдийг УИХ-аар соёрхон батлуулах | | Ажлын явц | “Далайн хөдөлмөрийн тухай” 2006 оны конвенцын 2016 болон 2018 оны нэмэлт, өөрчлөлтүүдэд нэгдэж орох нь зүйтэй гэж үзсэн тул конвенцын орчуулга, үзэл баримтлал, танилцуулга болон хуулийн төслийг боловсруул | **2-4-р улиралд:** УИХ-аар хэлэлцүүлж, батлуулна. | “Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын 2016, 2018 онуудын нэмэлт өөрчлөлтийн орчуулга, үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулж 2022 оны 09 дүгээр сарын 13-ний өдрийн 1/213 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Үүний дагуу Зам, тээврийн яам Гадаад харилцааны яамаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/2527 дугаар албан бичгээр хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран батлах хүсэлтээ хүргүүлээд байна. | **70** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ан 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 1/213 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. | | | |
| 2.4.3 | Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэл, хяналтын үйл ажиллагааг сайжруулах | | Үйл ажиллагааны хэрэгжсэн эсэх<br><br>Саатуулагдсан хөлөг онгоцны хэмжээ, хувь | 2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын далбаатай 9 хөлөг онгоц саатуулагд сан. | **1-2-р улиралд:** Олон улсын стандартад нийцсэн бүртгэл, хяналтын системийг нэвтрүүлнэ.<br>**2-улиралд:** Эрсдэлтэй хөлөг онгоцны бүртгэл явуулна.<br>**3-р улиралд:** Хамтран ажиллах гэрээ байгуулна.<br>**4-р улиралд:** Хөлөг онгоцонд тавих хяналт сайжирч, зөрчлийн тоо 20 хувиар буурна. | Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд 2022 онд АНУ-д хийсэн ажлын айлчлалын үеэр тус улсын Олон улсын аюулгүй байдал, зэвсэг үл дэлгэрүүлэх товчоотой албан уулзалт хийсний мөрөөр тус товчооны холбогдох албан тушаалтнууд өнгөрсөн 12 дугаар сард Монгол Улсад ажилласан бөгөөд Зам, тээврийн хөгжлийн яам болон Монгол Улсын Далайн захиргааны төлөөлөлтэй хийсэн уулзалтаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) хориг арга хэмжээг зөрчиж байгаа болон аливаа хууль бус үйл ажиллагаа явуулж буй хөлөг онгоцнуудыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэхээс сэргийлэхэд Монгол Улсад тусламж үзүүлэх зорилгоор “Эс Энд Пи Глобал” далайн тээврийн эрсдэлээс сэргийлэх бүртгэл, хяналтын мэдээллийн систем (хуучнаар Ай Эйч Эс Маркит гэх)-ийг 3 жилийн хугацаанд 3 хэрэглэгчийн нэвтрэх эрхтэйгээр үнэгүй ашиглуулах тухай мэдэгдсэн.<br>Улмаар АНУ-ын Төрийн Департаментын зүгээс Хамтран ажиллах тухай гэрээний төслийг 3 дугаар сарын 03-ны өдөр ирүүлснийг Монгол хэл рүү хөрвүүлэн ЗТХЯ-наас санал авахын сацуу ГХЯ-наас | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрээ байгуулах зөвшөөрөл авсан. Үүний дагуу 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр хамтран ажиллах гэрээг байгуулсан ба Далайн захиргааны албан хаагчид тус системд нэвтрэх нэр, хаяг авч үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.<br>Эрсдэлтэй хөлөг онгоцны 250 гаруй бүртгэлийн мэдээллийг АНУ-ын Сандиа үндэсний лабораторид хүргүүлж, эрсдэлийн үнэлгээний тайланг хүлээж авсан ба хувийг ЗТХЯ-ны ДАУЗТХ-т цахимаар хүргүүлсэн. | |
| **ЗОРИЛТ 2.5 "МОНГОЛ-САММОК ЛОЖИСТИК" ХАМТАРСАН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХИЖҮҮЛЭХ ТАЛААР АРГА ХЭМЖЭЭГ АВЧ АЖИЛЛАХ** | | **Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц** | | **"Монгол-Саммок Ложистик" хамтарсан компанийн 2021-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хамтран баталсан.** | | **ТУЗ-ийн хурлыг хуралдуулж, хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэлэлцүүлж, дүгнэлт саналыг боловсруулна.** | |
| 2.5.1 | "Монгол-Саммок Ложистик" хамтарсан компанийн үйл ажиллагааг идэвхижүүлэх талаар арга хэмжээг авч ажиллах | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц | "Монгол-Саммок Ложистик" хамтарсан компанийн 2021-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хамтран баталсан. | **2-р улиралд:**<br>Экспортын нүүрсийг далайгаар тээвэрлэн гуравдагч оронд тээвэрлэх судалгааг хийж, холбогдох дүгнэлт саналыг боловсруулна.<br>**4-р улиралд:**<br>ТУЗ-ийн хурлыг хуралдуулж, хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний | Хамтарсан компанийн талаарх танилцуулга, өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан болон тус компанийн цаг үеийн нөхцөл байдлын талаарх дүгнэлт, саналыг боловсруулан ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01/14 тоот албан тоот бичгээр хүргүүлсэн. ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаас 2023 оны 02 дугаар сарын 16-ний өдрийн 03/778 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу экспортын ачаа барааг далайгаар тээвэрлэх нөхцөл боломжийг судлах ажлыг төлөвлөн, холбогдох судалгааг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>БНХАУ, ОХУ-ын нүүрс тээвэрлэх боломжит далайн боомтуудын хүчин чадал, техник | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжилтийн явцыг хэлэлцэнэ. | тоног төхөөрөмжийн талаарх танилцуулга бэлтгэсэн.<br>Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ тариф болон худалдааны нөхцөлийн талаар харьцуулсан судалгаа хийгдсэн.<br>Нүүрсний далайн тээврийн үнийн судалгаа хийгдсэн.<br>Хөрш орнуудын далайн боомтоор дамжуулан гуравдагч оронд хамтарсан далайн тээврийн хөлөг онгоцоор тээвэрлэх боломжит хувилбар болон тээврийн зардлын судалгаа болон холбогдох дүгнэлт, саналыг 2023 оны цаг үеийн нөхцөл байдлаар шинэчлэн боловсруулав.<br>- Судалгааг нэгтгэн боловсруулж ЗТХЯ-нд 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/216 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| **ЗОРИЛТ 2.6 САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ, ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ** | | **Үйл ажиллагааны явц, хувь** | | **Далайн салбарын мэргэшүүлэх сургалтад 2022 онд 7 албан хаагчийг хамруулсан.** | | **Салбарын боловсон хүчнийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр ажиллаж, усан замын тээврийн салбарын мэргэжлийн зөвлөлийг байгуулна.** | |
| **Зам, тээврийн салбарын стратеги зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ** | | | | | | | |
| 2.6.1 | Гадаадын их, дээд сургууль, сургалтын төвүүдтэй хамтын ажиллагааг | | Үйл ажиллагаан ы явц, хувь | Далайн салбарын мэргэшүүлэх сургалтад 2022 онд 7 албан | **1-р улиралд:**<br>Салбарын боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх | Далайн захиргааны ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх 2023 оны сургалтын хөтөлбөр"-ийг 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр 06 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна. | **30** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өргөжүүлэх, боловсон хүчнийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах | | | хаагчийг хамруулсан. | талаар судалгаа хийж, сургалтын төлөвлөгөөг батална.<br>**2-4-р улиралд:**<br>Салбарын их, дээд сургууль, сургалтын төвүүдэд боловсон хүчнийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллана. | | |
| 2.6.2 | “Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах | | Журмын хэрэгжилт | Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн сангийн програмд жолооч бүртгэлийг нэмж, үнэмлэхийг QR кодтой хэвлэж байна.<br><br>“Усан замчны толь бичиг” ТББ-аас усан замын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтыг 2022 онд эхлүүлсэн | **1-р улиралд:**<br>Усан замын тээврийн салбарын мэргэжлийн зөвлөлийг байгуулна.<br>**2-р улиралд:**<br>Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний ажилтны сургалтад холбогдох мэргэжилтнүүдийг хамруулна.<br>**3-р улиралд:**<br>Мэргэжлийн шалгалтын комиссыг томилон ажиллуулна. | Журмын дагуу мэргэжлийн зөвлөлд салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулах зорилгоор “Монголын завьчдын нэгдсэн холбоо” НҮТББ, “Монголын усчин-аврагчдын холбоо” НҮТББ, “Монголын рафтингын холбоо” НҮТББ болон “Усан замчны толь бичиг” НҮТББ руу холбогдох албан тоотыг хүргүүлж, санал авсан.<br><br>Ирүүлсэн саналыг үндэслэн дээрх төрийн бус байгууллагууд болон Далайн захиргааны холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийг Далайн захиргааны даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/17 дугаар тушаалаар байгуулаад байна.<br><br>Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийг | **30** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бөгөөд тус ТББ-д үйл ажиллагаанд ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаас өгсөн чиглэлийн дагуу хяналт тавьж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | | үндэслэн Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/97, А/231 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам” хүчингүй болсон.<br><br>Тус асуудлаар Зам, тээврийн хөгжлийн яамнаас Боловсрол, шинжлэх ухааны яаманд асуудал шийдвэрлэх тухай албан тоот бичгийг хүргэгдсэн.<br><br>Зам, тээврийн хөгжлийн яамнаас тус асуудлыг шийдвэрлэх чиглэл өгсний дараа мэргэжлийн шалгалт авах ажлыг зохион байгуулна.<br><br>Далайн захиргаанаас “Усан замчны толь бичиг холбоо” ТББ-ын сургалтад бүрэн хамрагдсан иргэдээс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр шалгалт авахаар төлөвлөөд байгаа бөгөөд энэ талаар мэдэгдлийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/226 тоот албан бичгээр тус төрийн бус байгууллагад хүргүүлээд байна. | |
| **Зорилт 2.7 Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийг өргөжүүлж, техникийн үзлэг шалгалт хийх хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах** | | **Гэрээний тоо** | | **2022 онд хөлөг онгоц бүртгэлийн 1 агенттай гэрээ байгуулж, техникийн үзлэг шалгалт хэрэгжүүлдэг 7 хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай хамтран ажилласан.** | | **Хөлөг онгоцны бүртгэлийн зуучлагч 2-оос доошгүй агенттай гэрээ байгуулж, 7 хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын гэрээг шинэчлэн байгуулна.** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.7.1 | Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийг өргөжүүлэх | | Агентын тоо | 2022 онд хөлөг онгоц бүртгэлийн 1 агенттай гэрээ байгуулсан. | **2-р улиралд:** Хөлөг онгоцны бүртгэлийн зуучлагч 2-оос доошгүй агентыг судалж, хамтран ажиллах гэрээний нөхцөлийг тохиролцоно. **4-р улиралд:** Гэрээ байгуулж, хамтын ажиллагааг эхлүүлсэн байна. | Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд Сингапур улсад үйл ажиллагаа явуулдаг ENVISION HARVEST PTE LTD компанитай 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр хамтран ажиллах гэрээг байгуулсан. Мөн БНХАУ-д үйл ажиллагаа явуулдаг SING-LLOYD (CHINA) LIMITED компанитай 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хамтран ажиллах гэрээг байгуулаад байна. | **100** |
| 2.7.2 | Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцонд техникийн үзлэг шалгалт хийх хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах | | Шинэчлэн байгуулах гэрээний тоо | 2022 оны байдлаар техникийн үзлэг шалгалт хэрэгжүүлдэг 7 хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай хамтран ажиллаж байна. | **1-улиралд:** Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний төслийг шинэчлэн боловсруулна. **2-р улиралд:** Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулна. **4-р улиралд:** Шинээр гэрээ байгуулж, хамтын ажиллагааг эхлүүлнэ. | Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулсан бөгөөд гэрээний төслийг хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудад санал авахаар хүргүүлээд байна. | **70** |
| 2.7.3 | Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай | | Үйл ажиллагаан ы хэрэгжилт | Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч 6 аж | **3-р улирал** Хөвсгөл нуур, Өгийнуурт усан замын тээврийн | Хугацаа болоогүй. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвшөөрөлтэй иргэд, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих | | | ахуйн нэгж, 24 иргэний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, улсын бүртгэл, дугаар, техникийн хяналтын үзлэгт хамрагдсан эсэх, тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, нэмэлт дагалдах хэрэгсэл, аврах хантааз, техник ашиглалт, хувийн хэргийн хөтлөлт, боловсон хүчний хангалт, усан замын зогсоолд тавигдах шаардлага зэргийг шалгасан. | үйлчилгээ эрхэлж буй иргэд, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг шалгаж, шаардлага тавьж ажиллана. | | |
| **ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |

| ЗОРИЛТ 3.1 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛААР ХАНГАХ | | Тайлангийн хэрэгжилт | | Холбогдох төлөвлөгөөг жил бүр баталж, тайланг тогтсон хугацаанд хүргүүлж хэвшсэн. | | Арга хэмжээ 1, 4 хуулийн хэрэгжилтийн тайлан, тогтмол хүргүүлдэг 10 тайлан мэдээг тогтсон хугацаанд хүргүүлж, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллана. | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1. | Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах зорилгоор Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын зогсоолын орчмын хог хаягдлыг бууруулах чиглэлээр олон нийтэд сурталчилгаа хийх, эрэг дагуух хогийг цэвэрлэх нэгдсэн арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах | | Арга хэмжээ | Далайн захиргааны хэлтэс, албадуудын мэргэжилтнүүд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд нуурын эргийн дагуух хог, хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг 2022 онд зохион байгуулсан. | **3-р улиралд:** Нэгдсэн арга хэмжээг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулж, тайланг ЗТХЯ-нд хүргүүлнэ. | Хугацаа болоогүй. | |
| 3.1.2. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулах | | Төлөвлөгөөний хэрэгжилт | Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө батлагдсан. | **1-р улиралд:** ХАБЭА-н Орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны 2023 оны төлөвлөөг батлана. **2-р улиралд:** Хуулийн хэрэгжилтийн тайланг хагас жилийн байдлаар гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлнэ. | Далайн захиргааны ХАБЭА-ны орон тооны бус зөвлөлөөс 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Далайн захиргааны даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр батлуулсан ба төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэн ажиллаж байна. | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **4-р улиралд:**<br>Хуулийн хэрэгжилтийн тайланг жилийн эцсийн байдлаар гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлнэ. | Мөн ХАБЭА 4 дүгээр сарын аяны хүрээнд “Эрүүл аюулгүй ажил- Бидний суурь эрх” уриа дор хийгдсэн нэг сарын ажлын төлөвлөгөөг 2023.04.17-ны өдөр баталж төлөвлөгөөнд суугдсан ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн.<br><br>Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн салбарын улсын ерөнхий байцаагчийн “үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх тухай” албан даалгаврын биелэлт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 256 дугаар тушаалын хүрээнд Далайн захиргаанаас хийсэн ажлын 2023 оны эхний хагас жилийн тайлан болон Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар тус салбарт сүүлийн жилүүдэд гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн талаар мэдээлэл хийж, урьдчилан сэргийлэх, ослын мөрөөр дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэж, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай биелэлтийг тус тус ЗТХЯ-нд хүргүүлсэн. | |
| 3.1.3 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн | | Төлөвлөгөөний хэрэгжилт | Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтийн | **1-р улиралд:**<br>Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хүрээнд 2023 онд | Далайн захиргааны Жендерийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 03 дугаар | **70** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулах | | | хүрээнд 2022 оны хэрэгжилтийг тайлагнасан. | хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батална.<br>**2-3-р улиралд:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, холбогдох сургалтыг зохион байгуулна.<br>**4-р улиралд:**<br>Хэрэгжилтийн тайланг ЗТХЯ-нд хүргүүлнэ. | сарын 15-ны өдөр баталж, хэрэгжилтийг хангаан ажиллаж байна.<br><br>Төлөвлөгөөний дагуу нийт ажилтан албан хаагчдаас Жендерийн тухай ойлголт болон холбогдох сэдэвчилсэн сургалтын хэрэгцээг тодорхойлох санал асуулга авах ажлыг хоёрдугаар улиралд зохион байгуулсан. Санал асуулгын хүрээнд албан хаагчдын дунд 3-4 улиралд “Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль болон түүний хэрэглээ” сэдэвт сургалтыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. | |
| 3.1.4 | Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангаан ажиллах | | Төлөвлөгөөний хэрэгжилт | АТГ-аас зохион байгуулдаг сургалтуудад нийт ажилтнуудыг жил бүр хамруулж ирсэн ба Далайн захиргаанаас авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаан, тайлагнаж ажилласан. | **1-р улиралд:**<br>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батална.<br>**2-р улиралд:**<br>Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг эхний хагас жилийн байдлаар гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.<br>**4-р улиралд:**<br>Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жилийн эцсийн байдлаар гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлнэ. | .<br>Зам, тээврийн салбарт 2023 онд Авлигын эсрэг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг Далайн захиргааны авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд уялдуулан 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр баталсан ба төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг батлагдсан хугацаанд хэрэгжүүлж, эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлсэн ажлын тайланг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 1/205 тоот албан тоотоор ЗТХЯ-д хүргүүлсэн. | **100** |
| 3.1.5 | Ажилтнуудыг урамшуулах, салбарын шагналд | | Шагналын тоо | Ажлын үр бүтээмжтэй, бусдыгаа манлайлж | **4-р улиралд:**<br>Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үр дүнг дүгнэж, тухайн ажилтныг | Хүний нөөцийн мэдээлэл болон ажилчдын шагнал авсан мэдээллийг шинэчлэн ажилласан ба холбогдох шагналд тодорхойлох суурь шатны | **ХБ** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тодорхойлж, шагнуулах саналыг холбогдох яам, байгууллагад хүргүүлэх | | | ажилласан ажилтнуудыг холбогдох шагналд тодорхойлж, шагнуулах асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулдаг. | шагнуулах саналыг байгууллага, хамт олны саналаар дэмжсэн тохиолдолд зохих шагналд тодорхойлно. | ажлуудыг гүйцэтгэн шагнал олгох журмын дагуу зохих шаардлагыг хангаж буй албан хаагчдын мэдээллийг хүргүүлэхээр ажиллаж байна. | |
| 3.1.6 | Хүний нөөцийн удирдлагатай холбоотой нийтлэг үйлчилгээ, өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, ээлжийн амралтын хуваарь гаргах, ажлын үнэмлэх олгох, бүртгэл, судалгааг хөтлөх зэрэг хүний нөөцтэй холбоотой бүхий л асуудлыг цаг тухайд нь шийдвэрлүүлэх | | Шийдвэрлэлтийн хэрэгжилт | Тухай бүр хэрэгжилтийг хагуулсан. | **1-4-р улиралд:**<br>Хүний нөөцтэй холбоотой бүхий л асуудлыг цаг тухайд нь шийдвэрлүүлж ажиллана.<br><br>Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлуудыг хангаж ажиллана. /Төрийн бүтээмжийн сэргэлт/ | Далайн захиргааны даргын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн “Ээлжийн амралт батлах тухай” Б/06 дугаар тушаал батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Байгууллагын ажлын байрны сул орон тоо үүсэн тохиолдолд байгууллагын дотоод журамд заасны дагуу тус сул орон тоо үүсэн албан тушаалтны албан тушаалын тодорхойлолт заасан тавигдах шаардлагын дагуу байгууллагын цахим хаягт Хуурай боомт хариуцсан мэргэжилтэн болон Няравын ажлын байрны зарлан ил тод байдлыг ханган ажиллаж байна.<br><br>Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллах журам болон хүний нөөцтэй холбоотой бүхий л асуудлыг цаг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. | **70** |
| 3.1.7 | Ажилтнуудын нийгмийн баталгааны хөтөлбөрийг | | Хөтөлбөрийн хэрэгжилт | Далайн захиргааны ажилтнуудын нийгмийн баталгааны | **1-4-р улиралд:**<br>Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана. | Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжих хугацаа болоогүй байсан. | **70** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлж ажиллах | | | хөтөлбөр 2022 онд батлагдсан. | | Тус хөтөлбөрийн Нэг: Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх зорилтын дагуу албан хаагч тус бүр цалин, хөлсний нэмэгдэл, суутгал шимтгэл зэргийг тухай сар бүр хувийн цахим хаяг руу илгээн ажиллаж байна.<br><br>Хоёр: Албан хаагчдыг орон сууцаар хангах, амьдрах нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд байгууллагын нийт албан хаагчдаас нээлттэйгээр хүсэлтийг авсан бөгөөд 7 албан хаагч хүсэлт ирүүлсэн ба тус хүсэлтийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн байгууллагын бүх нийтийн хуралдаанаар хэлэлцэн олонхын саналаар 2 албан хаагчид дэмжлэг олгохоор шийдвэрлэсний дагуу Далайн захиргааны даргын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Б/30 дугаар тушаалаар дэмжлэгийг олгож шийдвэрлэсэн.<br><br>Гурав: Ажиллах орчин, нөхцөлийг дээшлүүлэх зорилтын дагуу 2023 оны төсөвт “Суурин компьютер худалдан авах ажил”-ыг тусгасан ба байгууллагын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгуулж, сонгон шалгаруулалт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгарсан “Дижитал” ХХК руу гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлэн ажиллаж байна.<br><br>Дөрөв: Ажилтны сурч, хөгжих боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх зорилтын дагуу 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 06 дугаар тушаалаар “Ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх 2023 оны сургалтын хөтөлбөр”-ийг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| 3.1.8 | Сайдын шуурхай хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, ЗТХЯ-нд тайлагнаж ажиллах | | Үүрэг даалгаврын биелэлт | Сайдын шуурхай хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж, дүгнүүлж хэвшсэн. | **1-4-р улиралд:**<br>Үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр ЗТХЯ-нд тайлагнаж ажиллана. | Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр ЗТХЯ-ны мэргэжилтэн А.Оюунболдод цахим шуудангаар хүргүүлж ажиллаж байна.<br><br>2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 11 удаагийн Сайдын шуурхай хуралдаанаас өгсөн Далайн захиргааны үйл ажиллагаатай холбоотой үүрэг, даалгаврын биелэлтийг 13 удаа тайлагнаж ажилласан байна. | 70 |
| 3.1.9 | Хууль, тогтоомж, удирдах дээд байгууллагын тогтоол, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, ЗТХЯ-нд | | Тайлангийн хэрэгжилт | Хэрэгжилтийг улирал бүр тайлагнаж, дүгнүүлж хэвшсэн. | **1-4-р улиралд:**<br>Хэрэгжилтийн тайланг ЗТХЯ-нд хүргүүлнэ. | Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланг 1 дүгээр улирлын байдлаар 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 01/65 тоот, хагас жилийн байдлаар 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/209 тоот албан бичгээр тус тус ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлсэн. | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлагнаж ажиллах | | | | | | |
| 3.1.10 | Сайд болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, ЗТХЯ-нд тайлагнаж ажиллах | | Тайлангийн хэрэгжилт | Хэрэгжилтийг улирал бүр тайлагнаж, дүгнүүлж хэвшсэн. | **1-4-р улиралд:** Хэрэгжилтийн тайланг ЗТХЯ-нд хүргүүлнэ. | Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн тайланг 1 дүгээр улирлын байдлаар 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 01/66 тоот, хагас жилийн байдлаар 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/215 тоот албан бичгээр тус тус ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлсэн. | 100 |
| 3.1.11 | Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэж, хэрэгжилтэд хяналт тавих | | Шийдвэрлэлтийн хувь | 2022 онд байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. | **1-4-р улиралд:** Иргэдийн өргөдөл, гомдлыг тухай бүр шийдвэрлэнэ. | 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар иргэдээс ирүүлсэн дараах өргөдлийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн. Үүнд:<br>- Усан замын тээврийн хэрэгслийг шинээр бүртгүүлэх /Иргэн М.Батсүх/<br>- Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийлгэх /Иргэн Б.Ширнэннамдин/<br>- Мөн Засгийн газрын олон нийттэй харилцах 11-11 төвд хандсан иргэн Б.Наранбаатарын гомдол, мэдээллийг БОАЖЯ-наас Далайн захиргаанд шилжүүлснийг хянан үзэж, 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/203 тоот албан бичгээр тус иргэнд хариу хүргүүлж шийдвэрлэсэн. | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ЗТХ-ийн сайдын 2022 оны Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх тухай А/50 дугаар тушаалын дагуу Далайн захиргаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын тайлан мэдээг 2023 оны эхний хагас жилийн байдлаар 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/204 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ТЗУГ-т хүргүүлсэн. | |
| 3.1.12 | Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу зохион байгуулж, баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллах | | Стандартын хэрэгжилт | Тогтмол гүйцэтгэдэг ажил үйлчилгээ | **1-4-р улиралд:**<br>Албан хэрэг хөтлөлтийг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу зохион байгуулна. | Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Баримт бичгийн стандарт MNS 5140:2021 зэрэг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг мөрдөн ажиллаж байна.<br>Байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлтөд “Эйбл” системийг ашиглаж байна. Ирсэн бичгийн хариуг хугацаанд нь өгөх, холбогдох арга хэмжээ авах талаар уг системийг ашиглан хяналт тавин ажиллаж байна. Мөн ирсэн, явуулсан албан бичгийн бүртгэлийн дэвтрийг тус тус хөтөлж байна.<br>2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар нийт 111 албан бичиг ирснээс хариутай 43 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж шийдвэрлэсэн.<br>Байгууллагаас явсан албан бичгийг “Эйбл” системийн бүртгэлд оруулан холбогдох байгууллагуудад цахимаар болон шуудангаар хүргүүлж ажиллаж байна. 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлаар нийт 215 албан бичиг явуулсан байна. | |
| 3.1.13 | Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдүүлж ажиллах, зөвлөмжөөр хангах | | Үйл ажиллагаан ы хэрэгжилт | Тогтмол гүйцэтгэдэг ажил үйлчилгээ | **2-р улиралд:**<br>Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батална.<br>**4-р улиралд:**<br>Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт хүлээлгэн өгнө. | Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам зэрэг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг мөрдөн ажиллаж байна.<br>Далайн захиргааны Баримт нягтлан шалгах комисс 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 2023 оны байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баталсан.<br>Бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэн нь хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлэх чиглэлээр холбогдох заавар, зөвлөгөөг нийт албан хаагчдад өгч ажиллаж байна.<br>2023 оны 1-р улирлын баримтыг архивын нэгж болгон бүрдүүлэхээр ажиллаж байна. | **100** |
| **ЗОРИЛТ 3.2 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, СТАТИСТИК МЭДЭЭ ГАРГАХ, ХЭРЭГЛЭГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ** | | **Ажлын явц** | | **Үйл ажиллагааны мэдээг улирал, хагас, бүтэн жилээр гаргаж холбогдох байгууллагуудыг мэдээллээр ханган ажилладаг.** | | **Статистик мэдээг нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлж, усан замын тээврийн хэрэгсэлд байршил тогтоох GPS төхөөрөмжийг суурилуулах талаар ААН, иргэдэд зохих шаардлага тавина.** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.1. | Усан замын тээврийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны статистик мэдээг нэгтгэн боловсруулах | | Ажлын явц | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 158 дугаар тушаалаар баталсан ”Усан замын тээврийн тээвэрлэлтийн жилийн статистикийн тайлан мэдээний маягтаар аж ахуйн нэгж, иргэдээс тээвэрлэлтийн мэдээг жил бүр нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлдэг. | **3-р улиралд:**<br>Усан замын тээврийн эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдээс тайлан, мэдээ авах ажлыг зохион байгуулна.<br>**4-р улиралд:**<br>Статистик мэдээг нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлнэ. | Хугацаа болоогүй. | |
| 3.2.2 | Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны мэдээг нэгтгэн боловсруулах | | Ажлын явц | Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны мэдээг улирал, хагас, бүтэн жилээр гаргаж холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангаж ажилладаг. | **1-4-р улиралд:**<br>Мэдээг гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлнэ. | Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны мэдээг 1-р улирлын байдлаар гарган 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01/68 тоот, хагас жилийн байдлаар 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/214 тоот албан бичгээр тус тус ЗТХЯ-нд хүргүүлсэн. | **100** |
| 3.2.3 | Усан замын тээврийн хэрэгсэлд байршил тогтоогч GPS төхөөрөмж суурилуулах талаар иргэд, | | Үйл ажиллагааны явц | “Тээврийн хэрэгслийн хяналтын систем”-ийг ашиглах, хамтран ажиллах гэрээг | **1-р улиралд:**<br>Хөвсгөл нууран дээр үүрэн телефоны сүлжээний тархцыг сайжруулах талаар холбогдох байгууллагад санал хүргүүлнэ.<br>**2-р улиралд:** | Хөвсгөл нууран дээр үүрэн телефоны сүлжээний тархцын хэмжилтийг 2023 оны 02 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд АТҮТ-тэй хамтран хийж гүйцэтгэсэн.<br><br>Сүлжээний тархцыг сайжруулахтай холбоотой үүрэн холбооны оператор | **90** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн этгээдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж шаардлага хүргүүлэх | | | АТҮТ-тай байгуулсан. | Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна.<br>**3-р улиралд:**<br>Усан замын тээврийн хэрэгсэлд байршил тогтоох GPS төхөөрөмжийг суурилуулах талаар ААН, иргэдэд зохих шаардлага тавина. | Юнител групп болон холбогдох байгууллагатай урьдчилсан байдлаар холбогдож санал солилцсон.<br><br>Хөвсгөл нууран дээр үүрэн телефоны сүлжээний тархцыг сайжруулах талаар 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01/70 тоот албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүсэлтээ уламжлаад байна.<br><br>Усан замын тээврийн хэрэгсэлд байршил тогтоогч GPS төхөөрөмж суурилуулах ажлыг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 07 дугаар сарын 04-ний өдрүүдэд Архангай, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий, Дорнод аймгуудад зохион байгуулан ажиллаж байна.<br><br>2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт усан замын 60 тээврийн хэрэгсэлд байршил тогтоогч GPS төхөөрөмжийг суулгаад байна. | |
| 3.2.4 | Байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгон сурталчлан ажиллах | | Үйл ажиллагаан ы явц | 2022 онд цахим хуудсыг шинэ мэдээллээр баяжуулан, Ил тод байдлын тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн. | **1-4-р улиралд:**<br>Цахим хуудаст шинэ мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулж, тайланг ЗТХЯ-нд хүргүүлнэ. | Цахим хуудаст шинэ мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулж, тайланг 14 хоног тутам Зам, тээврийн салбарын мэдээлэл хариуцсан ажлын хэсэгт цахимаар хүргүүлэн ажиллаж байна.<br><br>Далайн захиргааны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн ажлын тайланг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2023 оны эхний хагас жилийн байдлаар гарган 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/213 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ТЗУГ-т хүргүүлсэн. | |
| 3.2.5 | Цахимжуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж ажиллах | | Төлөвлөгөөний хэрэгжилт | Далайн захиргааны 2022 оны цахимжуулах үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангаж ажилласан. | **2-р улиралд:** Цахимжуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг батална.<br>**3-4-р улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж, ЗТХЯ-нд тайлагнана. | Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах төлөвлөгөөний төсөлд далай ашиглалт, усан замын тээврийн салбарын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 08-ны 1/30 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.<br><br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/60 дугаар тушаалаар батлагдсан "Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br><br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 2023 оны эхний хагас жилийн байдлаар гарган 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/210 тоот албан бичгээр ЗТХЯ-ны БТГ-т хүргүүлсэн. | **100** |
| **ЗОРИЛТ 3.3 САЛБАРЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ** | | **Ажлын явц** | | **Монгол Улс ОУДБ болон Ази, Номхон далайн бүс нутгийн далайн аюулгүй байдлын удирдлагуудын зөвлөлийн гишүүнээр элсэн орсон.** | | **Монгол Улс ОУДБ болон Ази, Номхон далайн бүс нутгийн далайн аюулгүй байдлын удирдлагуудын зөвлөлийн 23 дугаар зөвлөгөөний цахимаар зохион байгуулж, Олон улсын далайн байгууллагын Ерөнхий Ассамблейн хурал болон бусад** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **салбар хороодын холбогдох хурал зөвлөгөөнд оролцоно.** | |
| 3.3.1 | Олон улсын далайн байгууллаг-ын Ерөнхий Ассамблейн хурал болон бусад салбар хороодын холбогдох хурал зөвлөгөөнд идэвхтэй оролцож гишүүн орны хувьд ОУДБ-тай хамтын ажиллагааг өргөжүүлж ажиллана. | | Гадаад хамтын ажиллагаан ы шаардлага | Монгол Улс ОУДБ-д 1996 онд гишүүнээр элссэн бөгөөд 2 жил тутамд зохион байгуулагддаг Ассамблейн хуралд оролцож ирсэн. | **1-4-р улиралд:** Оролцох шаардлагатай хурал зөвлөгөөнүүдийн судалгааг гаргаж. ОУДБ-тай хамтын ажиллагааг өрнүүлж ажиллана. | ОУДБ-ын Олон улсын хөдөлгөөнт хиймэл дагуулын байгууллагын хурал 2023 оны 10 дугаар сарын 09-нөөс 13-ны өдрүүдэд зохион байгуулагдах тов гарсан.<br><br>Мөн, ОУДБ-ын Ерөнхий Ассамблейн 33 дугаар чуулган 2023 оны 11 дүгээр сарын 27-ноос 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулагдах тов гарсан. Чуулганы үеэр ОУДБ-ын зөвлөлийн гишүүн орнуудыг A, B, C ангилалд сонгох сонгуультай холбогдуулан Лондон дахь Монгол Улсын Элчин сайдын яамны зүгээс нэр дэвшигч орнуудын сонгуульт ажилд Монгол Улсаас дэмжлэг үзүүлэх тухай хүсэлт бүхий ноот бичгүүдийг Далайн захиргаанд ирүүлж байгаа бөгөөд хүсэлтүүдийг судлан үзэж, сонгуульд дэмжсэний хариуд сөргүүлэн тавих хамтын ажиллагааны саналыг боловсруулж байна.<br><br>Хугацаа болоогүй. | **30** |
| 3.3.2 | Ази, Номхон далайн бүс нутгийн далайн аюулгүй байдлын агентлагуудын удирдлагын зөвлөлийн 23 | | Арга хэмжээ зохион байгуулах /Тоо 1/ | Монгол Улсын Далайн захиргаа 2018 онд АФОМСА-д гишүүнээр элссэн бөгөөд БНСУ-д 2019 онд зохион | **1-р улиралд:** АФОМСА-гийн хэрэг эрхлэх газартай хамтран хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангана.<br>**2-р улиралд:** Зөвлөгөөнийг зохион байгуулна. | Ази, Номхон далайн бүс нутгийн далайн аюулгүй байдлын агентлагуудын удирдлагын зөвлөлийн (АФОМСА) 23 дугаар зөвлөгөөнийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/162 дугаар тушаалын дагуу Австралийн Далайн | **90** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дугаар ээлжит хурлыг зохион байгуулах */цахимаар/* | | | байгуулагдсан ээлжит хурлын үеэр 23 дугаар зөвлөгөөнийг Монгол Улс зохион байгуулах үүрэг хүлээсэн. | | аюулгүй байдлын захиргаатай хамтран Австралийн Холбооны Улсын Сидней хотноо 2023 оны 06 дугаар сарын 03-12-ны өдрүүдэд хамтран зохион байгуулж, ЗТХЯ-ны холбогдох төлөөлөгчид болон Далайн захиргааны дарга тэргүүтэй төлөөлөгчид зөвлөгөөнд оролцсон. зөвлөгөөнд Ази-Номхон далайн бүс нутгийн нийт 28 орны, Далайн салбарын удирдах түвшний байгууллагуудын удирдлагууд болох 120 төлөөлөгчид болон ажиглагчийн статусаар салбарын 9 ажиглагч олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцсон. - Зөвлөгөөнийг нээж Монгол Улсын Далайн захиргааны дарга үг хэлсэн бөгөөд хэлсэн үгэндээ АФОМСА-гийн үндсэн 4 зорилтуудыг хэрэгжүүлэхэд бүс нутгийн хамтын ажиллагаа ихээхэн чухал бөгөөд тэр дундаа далайн орчныг хамгаалахад далайд гарцгүй орны оролцоог дэмжих нь чухал ач холбогдолтой болохыг онцолсон. Зөвлөгөөний нээлтийн үйл ажиллагааг Австралид суугаа Монгол Улсын Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан бөгөөд морин хуур, хөөмий, уран нугаралт, үндэсний бүжгийн урлагийн тоглолт үзүүлсэн Зөвлөгөөний үеэр Монгол Улсын Далайн захиргааны зүгээс далайн орчныг хамгаалахад далайд гарцгүй Монгол Улсын оролцоо, далайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр сүүлийн үед авч хэрэгжүүлж буй Монгол Улсын үйл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа, далайн салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихэд Монгол Улсын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ гэсэн гурван сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн. Илтгэл бүрийн дараа БНСУ, БНХАУ, Кирибат, Канад, Австрали зэрэг улсын төлөөлөгчид Монгол Улсын далайн салбарт авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөлөг онгоцны бүртгэлээ сайжруулах чиглэлээр хийсэн ажил, хүчин чармайлтыг сайшааж, дэмжиж ажиллахаа илэрхийлсэн. Зөвлөгөөний үеэр ОУДБ, БНСУ-ын Далайн хэрэг, загас агнуурын яам, Далайн тээврийн аюулгүй байдлын захиргаа, Австралийн Далайн аюулгүй байдлын захиргаа, БНХАУ-ын Далайн аюулгүй байдлын захиргаа, Токиогийн Санамж бичгийн хэрэг эрхлэх газрын дарга, БНСВУ-ын Далайн захиргаа, АНУ-ын Эргийн хамгаалалтын захиргааны төлөөлөгчидтэй хоёр талт албан уулзалтууд хийж далайн салбар дахь хамтын ажиллагааны талаар санал солилцож, техникийн хамтын ажиллагааны хүрээнд дэмжлэг авах талаар хүсэлтээ илэрхийлсний дагуу айлын талаас дэмжиж ажиллахаа илэрхийлсэн. ОУДБ-ын Ази-Номхон далайн бүс нутаг хариуцсан байнгын төлөөлөгч Ноён Ситки Устаоглутай уулзсан уулзалтын үеэр далайд гарцгүй Монгол Улсын далайн салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, ОУДБ-д Монгол Улсын байнгын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөөлөгч суулгах талаар дэмжлэг үзүүлэх хүсэлт тавьсны дагуу санал солилцож, зохих ёсны дэмжлэг үзүүлэхээ ОУДБ-ын талаас илэрхийлсэн. Зөвлөгөөнийг хамтран зохион байгуулж буйд бүх төлөөлөгчид Монгол Улсын Далайн захиргаанд талархал илэрхийлсэн бөгөөд Монголын Үндэсний телевизээр уг үйл ажиллагааг шууд дамжуулан, Австралийн Далайн аюулгүй байдлын захиргааны дарга Монгол Улстай хамтран ажиллаж байгаадаа талархал илэрхийлж, далайн салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагааг сайшаасан тухай ярилцлага өгсөн. | |
| 3.3.3 | Ажилтнуудыг салбарын олон улсын хурал, зөвлөгөөн болон сургалт, семинарт хамруулах | | Үйл ажиллагааны явц | 2022 онд салбарын 7 хурал, зөвлөгөөн, 8 сургалт, семинарт 11 ажилтныг хамруулаад байна. | **1-4-р улиралд:** Холбогдох мэргэжилтнүүдийг олон улсын сургалт, семинарт хамруулна. | АНУ-ын Төрийн департаментаас Бүгд Найрамдах Кипр Улсын Ларнака хотод 2023 оны 02 дугаар сарын 26-наас 03 дугаар сарын 04-ний өдрүүдэд зохион байгуулсан “Үй олноор хөнөөх зэвсгийг түгээн дэлгэрүүлэгч орнуудад хэрэгжүүлж буй НҮБ-ын хориг арга хэмжээнд орсон хөлөг онгоцыг бүртгэхээс сэргийлэх үйл ажиллагаа” сэдэвт бага хуралд Хөлөг онгоцны бүртгэл хариуцсан мэргэжилтнийг хамруулсан. БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институт, Далайн аюулгүй байдлын захиргаатай 2022 онд байгуулсан гурван талт хамтын ажиллагааны Санамж бичгийн хүрээнд хөлөг онгоцон дээрх аюулгүй ажиллагаа, усан замын тээврийн хэрэгсэлд техникийн үзлэг, шалгалт явуулах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зааварчилгаа өгөх сургалтад холбогдох албан хаагчдыг 2023 оны 04 дүгээр сарын 23-наас 30-ны өдрүүдэд БНСУ-ын Бусан хотноо хамруулж, олон улсын сертификат авсан.<br>Тайландын Хаант Улсын Бангкок хотноо 2023 оны 05 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн далайн салбарын тогтвортой харилцааг хангах тухай хуралд Хуурай боомт хариуцсан нэгжийн холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан. | |
| 3.3.4 | Монгол Улсын Далайн захиргаатай холбогдож ажилладаг гадаадын эрх бүхий байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгүүдийн дагуу хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх | | Хамтын ажиллагааны шаардлага | Монгол Улсын Далайн захиргаа БНСВУ-ын Далайн захиргаа, БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институттэй БНХАУ-ын Далайн хэргийн газартай, БНХАУ-ын Лиаонин мужийн Жинжоу хотын Зам, тээврийг дэмжих төвтэй тус тус Санамж бичиг байгуулсан. | **1-4-р улиралд:**<br>Хамтын ажиллагааны баримт бичгийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хамтран ажиллана. | БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институт (KIMFT), БНСУ-ын Далайн тээврийн аюулгүй байдлын захиргаа (KOMSA)-г оролцуулсан гурван талт Санамж бичиг болон БНСУ-ын Далайн шинжлэх ухаан технологийн хүрээлэн (KIOST)-тэй далайн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгийг хүрээнд БНСУ-ын хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд тус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх “Монгол Улсын далайн тээврийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, дотоодын усан замын тээврийн хяналт, аюулгүй байдлыг сайжруулах төсөл”, “Монгол Улсын Хөвсгөл нуурын усан замын тээврийн судалгаа, хөгжлийн цогцолбор байгуулж, судалгааны усан онгоц нэвтрүүлэх төсөл”-ийн баримт бичгийг тус тус боловсруулан | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсын Сангийн яамаар дамжуулан БНСУ-ын Сангийн яаманд хүргүүлэх зорилгоор 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/24 тоот албан бичгээр ЗТХ-ийн сайдад хүргүүлсэн.<br><br>Улмаар Сангийн яамаар дамжин БНСУ-ын Элчин сайдын яаманд уламжлагдсанаар БНСУ-ын Сангийн яаманд хүргэгдээд байна. Уг төслийн баримт бичгүүдийг БНСУ-ын Хөгжлийн албан ёсны тусламж олгох асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас хянан үзсэний дагуу санхүүжилт олгох эсэх талаар эцсийн шийдвэр гарна.<br><br>БНСВУ-ын Далайн захиргаатай 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан далайн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгийн дагуу 2023-2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд санал оруулан айлын талд хүргүүлсний дагуу Вьетнамын Далайн захиргаанаас Тээврийн яамаараа хянан баталгаажуулах ажил хийгдэж байна.<br><br>АФОМСА-гийн зөвлөгөөний үеэр хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд холбогдох улсын төлөөлөгчидтэй албан уулзалтууд хийсэн. Үүнд: | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - БНСУ-ын талаас хоёр орны хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэхэд хамтарсан компанийн үйл ажиллагааг идэвхжүүлэх нь чухал гэдгийг онцолсон.<br>- БНСВУ-ын талаас хамтын ажиллагааны баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг ойрын хугацаанд эцэслэхээ мэдээлсэн. Түүнчлэн БНСВУ-ын далайн тээврийн их сургуульд 2 оюутан тэтгэлгээр оюутан сургах талаар хүсэлт тавьсны дагуу холбогдох мэдээллийг ойрын хугацаанд ирүүлэхээ айлын талаас мэдэгдсэн. | |
| 3.3.5 | Далайн салбар өндөр хөгжсөн бусад улсын далайн салбарын эрх бүхий байгууллагуудтай холбоо тогтоож хамтын ажиллагааг өргөжүүлж ажиллах | | Гадаад хамтын ажиллагааны шаардлага | Монгол Улс ОУДБ болон Ази, Номхон далайн бүс нутгийн далайн аюулгүй байдлын удирдлагуудын зөвлөл (APhOMSA)-ын гишүүнээр элсэн орсон. | **1-2-р улиралд:**<br>Хамтран ажиллах боломжтой байгууллагын судалгааг хийнэ.<br>**3-р улиралд:**<br>Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар мэдээлэл солилцоно.<br>**4-р улиралд:**<br>Монгол Улсын Далайн захиргаатай ижил түвшний 1-2 байгууллагуудтай шинээр холбоо тогтоож, хамтран ажиллах саналыг хүргүүлнэ. | Австралийн Холбооны Улс (АХУ)-ын Далайн Аюулгүй байдлын захиргаа (АХУДАБЗ)-тай далайн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгийн төслийг боловсруулан 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдөр цахим шуудангаар хүргүүлсэн. АФОМСА-гийн зөвлөгөөний үеэр АХУДБАЗ-тэй хийсэн албан уулзалтын үеэр Австралийн талаас ойрын хугацаанд хамтын ажиллагааны Санамж бичгээ эцэслэн тохирч, ОУДБ-ын Ассамблейн үеэр буюу 2023 оны 11 дүгээр сард Лондон хотноо байгуулах саналаа илэрхийлсэн. ОУДБ-ын Зөвлөлийн гишүүн орны сонгуульд АХУ-ыг Монгол Улсын зүгээс дэмжих тухай хүсэлт тавьсан. Монгол Улсын талаас Далбааны эзэн улсын байцаагчдыг мэргэшүүлэх, хамтарсан үзлэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгалт хийх талаар хүсэлт тавьсныг айлын талаас дэмжиж ажиллахаа илэрхийлсэн.<br><br>Гадаад харилцааны яам, Австралийн Худалдаа хөрөнгө оруулалтын хороо хоорондын цахим уулзалтын яриаиы сэдэвт тусгах Австралийн Холбооны Улстай далайн салбарт хамтран ажиллах саналыг дээрх Санамж бичгийн төслийн хамт Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Элчин сайдын яаманд цахим шуудангаар хүргүүлсэн.<br><br>Далайн захиргаа болон АХУДАБЗ хамтран зохион байгуулах АФОМСА-гийн ээлжит 23 дугаар зөвлөгөөнийг Далайн захиргаанаас даргалж оролцох болсонтой холбогдуулан хоёр орны далайн тээврийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцох уулзалт хийх хүсэлтийг АХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд хүргүүлсний дагуу албан уулзалт хийж, хоёр орны далайн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар хэлэлцсэн.<br><br>Тайландын Хаант Улсын Далайн захиргаатай далайн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгийн төслийг ЗТХЯ болон ГХЯ-аар хянуулсны дагуу 2022 оны 08 дугаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 03-ны өдрийн 1/186 тоот албан бичгээр Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Элчин сайдын яаманд хүргүүлсний дагуу айлын талаас саналаа оруулан ирүүлсэн. Санамж бичгийг эцэслэн тохирох цахим уулзалтыг 7 дугаар сард зохион байгуулахаар харилцан тохиролцсон.<br><br>БНСУ-ын Бусан хотноо Далайн захиргааны Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга холбогдох мэргэжилтний хамт томилолтоор ажиллах үеэр БНСУ-ын Далайн хэрэг, загас агнуурын яам, Далайн тээвэр, загас агнуурын технологийн институт, Далайн тээврийн аюулгүй байдлын захиргаа, Далайн тээврийн институтийн удирдлагуудтай албан уулзалт хийж хамтын ажиллагааг өргөжүүлэх, боловсруулсан төслийг амжилттай хэрэгжүүлэх талаар хэлэлцсэн. Улмаар БНСУ-ын Далайн тээврийн институттэй хамтын ажиллагааг эхлүүлэх талаар хэлэлцэж, Санамж бичиг байгуулахаар тохиролцсон. Санамж бичгийн төслийг боловсруулж байна. | |
| 3.3.6 | Далайн тээврийн салбартай холбоотой эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллаж заавар, | | Судалгааны үе шат | Хамтын ажиллагаа тогтоох чиглэлээр ажиллаж байна. | **1-р улиралд:**<br>Салбарын эрдэмтэдтэй холбоо тогтоож, хамтын ажиллагааг эхлүүлнэ.<br>**2-р улиралд:**<br>Гуравдагч орны боомтын үйл ажиллагаатай танилцаж, чингэлэг | Салбарын үйл ажиллагаанд шаардлагатай зөвлөгөө, зөвлөмж авах зорилгоор дараах эрдэмтэн судлаачидтай холбоо тогтоож, хамтран ажиллав. Үүнд:<br>-Дэлхийн Далайн Их сургуулийн Далайн тээвэр, боомтын менежментийн багийн профессор | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөмж авч ажиллах. | | | | тээврийн бараа бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх боломжийг судална. | Дон-Вок Сон (Dong-Wook Song): Далайд гарцгүй орны хувьд тээвэр, логистикийн асуудлыг хөнгөвчлөхөд шаардлагатай олон улсын эрх зүйн баримт бичгүүдийн талаар холбогдож мэдээлэл, зөвлөгөө авч ажилласан;<br>-Олон Улсын Далайн хиймэл дагуулын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, далайн тээврийн доктор Моин Ахмед: Хуурай боомтын чиглэлээр зөвлөгөө мэдээлэл авч ажилласан ба хуурай боомтыг байгуулахад төслийн зөвлөхөөр ажиллах боломжтой талаараа мэдэгдсэн;<br>-UNCTAD Олон Улсын байгууллагын тээвэр логистик хариуцсан доктор Ян Хоффмэн (Jan Hoffman): Хуурай боомтын талаар санал солилцсон ба Хуурай боомтын асуудлыг тус байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлтсийн дарга Паул Хансон хариуцдаг болохыг мэдэгдэж холбоо барих хаягийг ирүүлсэн болно.<br>- ХБНГУ-ын Шпейерын Төрийн удирдлагын их сургуулийн Эдийн засгийн болон тээврийн бодлогын Проф.Др. (хүндэт доктор) Андреас Кноррийг Монгол Улсад ажиллах үеэр хүсэлт гарган 2023 оны 04 дүгээр сарын 14-нд Далайн захиргааны байранд уулзалт хийж, Европын холбооны улсуудын тээвэр, логистикийн эрх зүйн байдал тэр дундаа далайд гарцгүй Чех улсын тээвэр логистикт эзлэх байр суурийн талаар асууж тодруулсан ба цаашид | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтарч ажиллах боломжийн талаар санал солилцож ажиллав.<br><br>Бүгд Найрамдах Казахстан Улсын Хоргос боомтын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, туршлага судлах зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 03-06-ны өдрүүдэд ЗТХЯ, ДЗ, УБТЗ, МТЗ, МТЗНХ зэрэг байгууллагын төлөөллийг оролцуулан томилолтоор ажилласан. Томилолтын тайланг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/120 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн бөгөөд тус тайландаа далайд гарцгүй Казахстан улс хуурай боомт байгуулах замаар чингэлэг тээврийн тасралтгүй урсгалыг хэрхэн зохион байгуулж буй туршлагыг судалж, Монгол Улсад хэрэгжүүлэх арга замын талаар тусгасан болно. | |
| **ЗОРИЛТ 3.4 ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ** | | **Ажлын явц** | | **2022 оны гүйцэтгэл, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж, дүгнүүлсэн.** | | **Далайн захиргааны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөг хуваарийн дагуу биелүүлж, улсын төсөвт батлагдсан хуваарийн дагуу 250 сая төгрөгийг төвлөрүүлнэ.** | |
| 3.4.1 | Олон улсын хөдөлгөөнт хиймэл дагуулын аудитын төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулах | | Аудитын төлбөрийг төлж барагдуулсан байна. | Хөлөг онгоцны байршил тогтоох, алсын зайнаас хянах байгууллагатай гэрээ байгуулсан. | **3-р улиралд:** Аудитын тайланг үндэслэн аудитын төлбөрийг төлж барагдуулна. | 2023 оны 03 дугаар сарын 21-ний 119/А0150055 Үндэсний аудитын төлбөр барагдуулах актад заасан 36 189 647.00 /гучин зургаан сая нэг зуун наян есөн мянга зургаан зуун дөчин долоог төгрөг/ 2023 оны 06 сарын 13-ны өдөр төрийн сангийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 100900000601 тоот дансанд төвлөрүүлсэн. | |
| 3.4.2 | Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг биелүүлэх | | Улсын төсөвт батлагдсан хуваарийн дагуу 250 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. | Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд хөлөг онгоцны бүртгэлийн орлогоос 250,0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр заасан. | **1-4-р улиралд:** Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хуваарийн биелүүлнэ. | Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хуваарийн дагуу 2-р улирлын байдлаар 120.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. | 100 |
| 3.4.3 | Далайн захиргааны 2023 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгагдсан урсгал зардлын гүйцэтгэл, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлж, тайлагнах, зарцуулалтад хяналт тавих | | Далайн захиргааны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөг хуваарийн дагуу биелүүлсэн байна. | 2022 оны гүйцэтгэл, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж, дүгнүүлэв. | **1-4-р улиралд:** Орлого, зарлагын төлөвлөгөөний биелэлт хуваарийн дагуу хангагдсан байна. | Далайн захиргааны 2023 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/18 дугаар тушаалаар баталсан.<br><br>Нийт эхний хагас жилийн байдлаар цалингийн зардал 500.7 саяас 316.4 сая төгрөг, НДШ 62.0 саяас 39.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 100.5 сая төгрөгөөс 103.6 төгрөг, хангамж бараа материалын зардал 67.0 сая төгрөгөөс 66.2 сая төгрөг, Томилолтын зардал 162.5 сая төгрөгөөс 167.5 сая төгрөг, Бусад зардал 314.0 сая төгрөгөөс 260.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Мөн төсвийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу худалдан авалтын төлөвлөгөөнөөс 180.0 сая төгрөг хэмнэн ажиллаж байна. | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.4 | Үндэсний аудитын газар болон бусад хяналт шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах | | Албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. | 2022 онд Үндэсний аудитын газраас ирүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийг хуулийн хугацаанд хэрэгжүүлж тайлагнав. | **4-р улиралд:** Зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн тухай албан бичгийг ЗТХЯ-нд хүргүүлнэ. | 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудитын шалгалтын актыг 6 дугаар сард бүрэн барагдуулсан ба аудитын зөвлөмжийн төлөвлөгөөний биелэлтийг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллана. | ХБ |
| 3.4.5 | “Төсвийн тухай хууль”, Шилэн дансны тухай хуулийн дагуу санхүүгийн гүйлгээг сар, улирал, хагас, бүтэн жил тутам ил тод мэдээлж байгаа байдалд хяналт тавьж, цахимаар Сангийн яаманд хүргүүлж, баталгаажуулах | | Хуулийн хэрэгжилт | Тухайн жилийн санхүүгийн гүйлгээг сар, улирал, хагас, бүтэн жил тутам ил тод мэдээлж байгаа байдалд хяналт тавьж, цахимаар Сангийн яаманд хүргүүлж ажилладаг. | **1-4-р улиралд:** Сар, улирал, бүтэн жилээр Сангийн яам болон Зам, тээврийн хөгжлийн яаманд 100 хувь ил тод мэдээлж ажиллана. | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд тайлан мэдээг оруулж байгаа бөгөөд 2023 оны 1-6 дугаар сарын байдлаар нийт 173 мэдээ мэдээлэхээс хугацаандаа оруулсан 164 мэдээ, хугацаа хоцроосон 9 мэдээ байна.<br><br>Цаашид хуулийн хугацаанд тайлагнахад анхаарч ажиллана. | 90 |
| 3.4.6 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, худалдан авах ажиллагааг | | Худалдан авах ажиллагааг Далайн захиргааны үйл ажиллагааны орлого, зарлагын батлагдсан төлөвлөгөөн | Худалдан авах ажиллагааны тайланг улирал бүр ЗТХЯ-нд хүргүүлж хэвшсэн. | **1-4-р улирал:** Тухайн онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааг улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар ЗТХЯ-нд тайлагнана. | ЗТХ-ийн сайдын 2023 оны А/18 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар Далайн захиргааны 2023 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлын жагсаалтыг баталсны дагуу Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг www.tender.gov.mn хуудаст оруулж, батлуулсан. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ЗТХЯ-нд тайлагнаж ажиллах | | ий хүрээнд зохион байгуулсан байна. | | | Тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хороог Далайн захиргааны даргын тушаалаар байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулах ажлын хүрээнд барилгын ажлын даалгаврыг боловсруулж, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд зарласан. Бүтээн байгуулалтын ажлуудын тендерийг амжилттай зохион байгуулсан ба барилгын угсралтын ажлууд эхлээд байна. Үүнд:<br><br>1. Тендер шалгаруулалтын нэр: Тусгай зориулалтын завины зогсоол байгуулах (Хөвсгөл, Хатгал)- Санал ирүүлсэн оролцогч байгаагүй тул дахин зарлахаар ажиллаж байна.<br>Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302003<br>2. Тендер шалгаруулалтын нэр: Суурин компьютер нийлүүлэх<br>Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302005<br>- гэрээ байгуулахаар болсон<br>3.Тендер шалгаруулалтын нэр: Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол байгуулах (Орон нутагт)<br>Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302002<br>- гэрээ байгуулахаар болсон<br>4.Тендер шалгаруулалтын нэр: Өргөгч кран<br>Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302006-гэрээ байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5.Тендер шалгаруулалтын нэр: Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол (Улаанбаатар 1, орон нутаг 1) барих ажил<br>Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302002 - гэрээ байгуулахаар болсон /Ховд/<br>6.Тендер шалгаруулалтын нэр: Хяналтын пост (Архангай, Өгийнуур)<br>Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302001- дахин зарлахаар ажлын даалгаварт өөрчлөлт оруулж байна. | |
| **ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **ЗОРИЛТ 4.1 ДАЛАЙН БОЛОН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР ХАНДСАН ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨГӨӨР ХАНГАН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ АЖИЛЛАХ** | | **Ажлын гүйцэтгэлийн явц** | | **Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-аар дамжуулан усан замын тээврийн хэрэгслийг шинээр бүртгүүлэх, бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх, хасалт хийлгэх хүсэлтийг хүлээн аван шийдвэрлэх боломжтой болсон.** | | **Сургалт, семинарыг зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллана.** | |
| 4.1.1. | Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэх, гэрчилгээ, улсын дугаар олгох, шилжилт, | | Ажлын гүйцэтгэлийн явц, шийдвэрлэлт | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-аардамжуулан усан замын тээврийн хэрэгслийг | **1-4-р улиралд:**<br>Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангаж, ирүүлсэн хүсэлт, өргөдлийг | 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар шинээр бүртгүүлэх-11, шилжилт хөдөлгөөн-5, хасалт хийлгэх-0 нийт 16 хүсэлт, өргөдлийг E-Mongolia-аар дамжуулан хүлээн авч, тус тус шийдвэрлээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлгөөн хийх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэх | | | шинээр бүртгүүлэх, бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх, хасалт хийлгэх хүсэлтийг хүлээн аван шийдвэрлэх боломжтой болсон.<br>2022 оны байдлаар улсын бүртгэлд нийт 162 тээврийн хэрэгслийг бүртгэж, гэрчилгээ, улсын дугаар олгосон. | шийдвэрлэсэн байна. | Улсын бүртгэлд нийт 189 усан замын тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн байдлаар шинээр бүртгүүлэх-25, шилжилт хөдөлгөөн-8, хасалт хийлгэх-0 нийт 25 хүсэлт, өргөдлийг E-Mongolia-аар дамжуулан хүлээн авч, тус тус шийдвэрлэсэн.<br><br>Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэх, шилжилт хөдөлгөөн хийлгэхээр талаар мэдээлэл, зөвлөгөө авахаар Далайн захиргаанд хандсан 35 ААН, иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. | |
| 4.1.2 | “Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт семинарыг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулах | | Арга хэмжээ зохион байгуулах | Усан замын тээврийн хөвөлтийн улирал эхлэх үед хамтарсан семинарыг жил бүр Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Архангай аймгийн Өгийнуур суманд тус тус зохион байгуулдаг. | **3-р улиралд:** Сургалт, семинарыг зохион байгуулж, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хамруулна. | “Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Соёлын төвд зохион байгуулсан. Семинарт Зам, тээврийн хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар, Хөвсгөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хөвсгөлийн Тусгай хамгаалалтын газар, Хөвсгөлийн Эгийн голын сав газрын захиргаа, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын аврах 69-р анги, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл нийт 110 гаруй оролцогчтойгоор зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.3 | Монгол Улсын экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг хөрш орнуудын боомтоор дамжуулан тээвэрлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд оролцогч байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын хооронд зөвлөлдөх уулзалт, ярилцлагыг зохион байгуулах | | Арга хэмжээ зохион байгуулах | “Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо” ТББ-тай 2018 онд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд жил бүр зохион байгуулахаар тусгагдсан. | **2-р улиралд:** Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж мэдээлэл солилцож ажиллана.<br>**4-р улиралд:** Семинар хэлэлцүүлгийн арга хэмжээг зохион байгуулна. | МТЗНХ-ны гишүүн Туушин ХХК-тай 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын импортын ачаа тээврийн бөглөрөл, үүсээд байгаа цаг үеийн нөхцөл байдал, хүндрэлийн талаар мэдээлэл солилцож ажилласан ба Улаанбаатар хотыг түшиглэсэн нэгдсэн терминалын хүрээнд шийдвэрлэх боломжийн талаар холбогдох төслийн танилцуулгатай танилцаж, мэдээлэл солилцож ажиллав.<br><br>МТЗНХ-ны гишүүн Ландбридж ХХК-иас 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Мэдээлэлтэй харилцагч” арга хэмжээнд оролцож “Далайн тээвэр болон боомт ашиглалт”-ын талаар төрөөс барьж буй бодлого, Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийг гадаад худалдаа, тээвэрлэлтэд оролцож буй иргэн, аж ахуйн нэгжид таниулах илтгэл тавьж хамтарч ажиллав.<br><br>Санамж бичгийн хүрээнд Далайн захиргаанаас 2023 оны 06 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулсан “Хуурай боомтыг хөгжүүлэх замаар хил дамнасан дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх санаачилгууд” сургалтад тус холбооны төлөөлөн удирдах зөвлөл болон гишүүн байгууллагуудыг оролцуулав. | 100 |
| 4.1.4 | Монгол Улсын ашиглаж болох хөрш зэргэлдээ орнуудын боомтын хүчин чадлын | | Судалгааны үе шат | Монгол Улсын далайд гарах гарц судалгааны эмхтгэл 2017 онд хэвлэгдсэн. | **2-р улиралд:** Хөрш орнуудын боомтын мэдээлэл, судалгаа хийж гүйцэтгэнэ. | Хөрш орнуудын далайн боомтуудын танилцуулга, судалгааг боловсруулж эмхэтгэлийн мэдээллийн санг шинэчлэн боловсруулав. Үүнд:<br>- БНХАУ-ын жил бүр шинэчлэн гаргадаг боомтын эмхэтгэлийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судалгааг боловсруулж, танилцуулга бэлтгэх | | | | **4-р улиралд:** Судалгааг салбарын эрдэмтэн судлаачаар хянуулж, эмхтгэл болгон хэвлүүлнэ. | цахимаар худалдан авч Монгол Улсын ашиглах боломжтой 2014 хэлэлцээрийн боомтуудын талаарх статистик, мэдээллийг түүвэрлэн орчуулж бэлтгэсэн;<br>- ОХУ-ын боомтуудын мэдээллийг цахим хуудас болон албан эх сурвалжуудаас хэрэгцээтэй мэдээллийг түүвэрлэж, орчуулж бэлтгэсэн;<br>Далайн тээвэр, боомтын үйл ажиллагаанд нэвтэрч буй шинэ техник, технологийн талаар судалж холбогдох мэдээллийг цуглуулж бэлтгэв. | |
| 4.1.5 | Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвтэй хамтарч ажиллах | | Төлөвлөгөөний хэрэгжилт | НҮБ-ын Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон Улсын судалгааны төвтэй 2013 оноос санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна. | **2-р улиралд:** ДГХБО-ын ОУСТ-тэй хамтран ажиллах тухай Санамж бичгийг шинэчлэн байгуулж, төлөвлөгөө гарган ажиллана.<br>**4-р улиралд:** Төлөвлөгөөг үе шаттай хэрэгжүүлж ажиллана. | Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвтэй Хамтын ажиллагааны санамж бичгийг 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр шинэчлэн байгуулсан ба тус баримт бичгийн хүрээнд 2023-2024 онуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав. Төлөвлөгөөний хүрээнд тус төвийн гишүүн далайд гарцгүй Казахстан улсын Хоргос хуурай боомтын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлын хүрээнд мэдээлэл солилцож, холбогдох байгууллагуудаас дэмжлэг хүсэх талаар хамтарч ажилласан.<br><br>Хамтарсан төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцох уулзалтыг 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдөр НҮБ-ын байранд зохион байгуулж, тус Судалгааны төвийн гишүүн, далайд гарцгүй бусад орнуудад тулгарч буй эдийн засгийн хүндрэл, тэдгээрийг даван туулж буй туршлагын талаар мэдээллийг гишүүн орнуудад хүсэлт тавих замаар авах, далайд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарцгүй Европын холбооны улс болох Бүгд Найрамдах Чех Улсын хуурай боомтын талаар мэдээлэл авах тухай хэлэлцэн тохиролцов. | |
| 4.1.6 | Ковид-19 цар тахлын дараах далайн тээврийн үнэ тарифын талаар судлах | | Судалгааны үе шат | Тээврийн үнэ тариф өөрчлөгдсөн. | **1-р улиралд:** Далайн тээврийн үнэ, тарифын талаар судалгаа хийж, ЗТХЯ-нд хүргүүлнэ. | Судалгааг нэгтгэн боловсруулж 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/86 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. | 100 |

***Төлөвлөгөөг хянасан:*** ***Төсвийн ерөнхийлөн захирагч***
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
.............................. /С.БЯМБАЦОГТ/

***Төлөвлөгөө тайлагнасан:*** ***Төсвийн шууд захирагч***
ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГА .............................. /Д.ОТГОНСҮРЭН/